

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**Агуулга**

1.Аудитын гэрчилгээ .....	2
2.Аудитын тайлан.....	4
2.1. Оршил .....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4. Байгууллагын зорилго,үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	4
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	6
2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	7
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
3. Менежментийн захидал .....	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан .....	13
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	14
4.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....	16
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	17

**Товчилсон үгийн жагсаалт**

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн, өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2020.03.13 № 06/814  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Аудитын гол асуудал

Зорилтот түвшний төлөвлөгөө батлуулаагүй, оны эцэст харилцах дансны үлдэгдэл хүрэлцээтэй байсан үед нэмэгдсэн өртгийн албан татварын өглөгийг төлөөгүй дансны өглөгийг нэмэгдүүлсэн 36.5 сая төгрөг эдгээр зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

## Үүрэг, хариуцлага

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ-ын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2.Аудитын тайлан

### 2.1. Оршил

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ-ын захирал Э.Цогтгэрэл танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ-ын удирдлага нь санхүүгийн тайлангаа Төсвийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 12 дугаар сарын 23-наас 2020 оны 3 дугаар сарын 11-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Баян ташаагийн эх Аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 1/027 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

### 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ нь үйл ажиллагааны зорилгоо “Төр, хувийн хэвшил, эрдэм шинжилгээний байгууллагын хамтын ажиллагаанд суурилсан инновацийн тогтолцоог хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах өрсөлдөх чадвар бүхий үндэсний компаниудыг төлөвшүүлэх, мэдээллийн технологийн өндөр ур чадвартай боловсон хүчнийг хөгжүүлэх” гэж тодорхойлсон.

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ-ын үйл ажиллагааны чиглэлийг мэдээлэл технологийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх данснаас хасах, шилжүүлэх, журам батлах тухай ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоол
- Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай 2019 оны 268 дугаар тогтоол;

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Новософт ХХК-ийн “Бааз” программ хангамж ашиглаж байна.

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 11 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 828.9 сая төгрөгөөс тооцон 8.3 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшин 2019 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 1,118.1 сая төгрөгөөс 1.0 хувиар тооцож 11.2 сая төгрөгөөр тогтоолоо.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8.9 сая төгрөгөөр буюу 0.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	29.8	66.5	36.7
Авлага	80.4	190.0	109.6
Урьдчилж төлсөн зардал	0.5	9.5	9.0
Бараа материал	65.0	70.2	5.2
Үндсэн хөрөнгө	3,812.3	3,642.8	(169.5)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>3,988.0</b>	<b>3,979.0</b>	<b>(9.0)</b>
Өр төлбөр	278.2	298.6	20.4
Урьдчилж орсон орлого	20.4	6.2	(14.2)
Эздийн өмч	3,689.4	3,674.2	(15.2)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>3,988.0</b>	<b>3,979.0</b>	<b>(9.0)</b>

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 36.7 сая төгрөгөөр өссөн нь борлуулалтын орлого өссөнтэй холбоотой.

Авлага дансны үлдэгдэл 109.6 сая төгрөгөөр өссөн нь Нью тур сафарис ХХК-аас авах түрээсийн төлбөрийн үлдэгдэл 40.6 сая төгрөгөөр, Ай Си Ти групптэй байгуулсан "Хамтран ажиллах гэрээ"-ний төлбөрийн үлдэгдэл 61.4 сая төгрөгөөр тус тус нэмэгдснээс шалтгаалсан.

Урьдчилж төлсөн зардал дансны үлдэгдэл 9.0 сая төгрөгөөр өссөн нь ТӨБЗГ-ын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А-1/4451 тоот зөвшөөрлөөр тус байгууллагын захирал Изриаль улсын Кибер технологийн парк болон мэдээллийн технологийн паркуудтай уулзаж, туршлага судлах томилолтын зардлыг урьдчилан шилжүүлсэнтэй холбоотой байна.

Хангамжийн материалын үлдэгдэл 5.2 сая төгрөгөөр өссөн нь бараа материалын үлдэгдэл нэмэгдэхэд нөлөөлсөн.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь ТӨБЗГ-ын 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн А-5/1084, 2019 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн А-1/3527 тоот шийдвэрийг үндэслэн машин тоног төхөөрөмжийн данснаас 59.2 сая төгрөг, тавилга эд хогшлын данснаас 0.7 сая төгрөг нийт 59.9 сая төгрөгийн хөрөнгө акталсан болон тайлант онд байгуулсан үндсэн хөрөнгийн элэгдэлтэй холбоотой.

Өр төлбөр дансны үлдэгдэл 20.4 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны эцэст НӨАТ-ын өглөг өссөнөөс шалтгаалсан байна. Нийт өглөгийн үлдэгдэл 298.6 сая төгрөг байгаагаас урт хугацаат өглөг 4.9 сая, богино хугацаат өглөг 293.7 сая төгрөг байна. Тухайлбал: Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын өглөг 100.0 сая, нэмэгдсэн өртгийн албан татварын өглөг 96.3 сая, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт төлөх түрээсийн өглөг 70.3 сая, түрээслэгч байгууллагуудын түрээсийн барьцаа 27.1 сая төгрөгийн тус тус үлдэгдэлтэй байна.

## 2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д заасны дагуу аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын дарга нь гэрээ байгуулахдаа байгууллагынхаа эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж, хүргэх түвшингээ тодорхойлж, мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д зааснаар эрх, үүргээ хэрэгжүүлнэ.

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ нь Нью тур сафарис ХХК-тай түрээсийн гэрээ байгуулаагүйн улмаас тухайн онд зорилтот түвшин батлагдаагүй бөгөөд 2018 оноос 2023 оны хооронд хэрэгжүүлэх дунд хугацааны зорилтын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж ирсэн байна. 2019 онд үндсэн үйл ажиллагаанаас 803.7 сая төгрөг, төлбөртэй сургалтын орлого 298.4 сая төгрөг, хүүгийн орлогоос 0.8 сая төгрөг нийт 1,102.7 сая төгрөгийн орлогыг бүрдүүлсэн нь өмнөх оноос 284.7 сая төгрөгөөр өссөн байна.

Тайлант оны үйл ажиллагааны нийт зардал 1,118.1 сая төгрөг, үүнээс ерөнхий ба удирдлагын зардал 887.2 сая, борлуулалт, маркетингийн зардал 49.4 сая төгрөг зарцуулсан байна.

## 2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 11 эрсдэл тодорхойлж нийт 11 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар илэрсэн нийт 43.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 6.7 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 36.5 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгч менежментийн захидалд тусгалаа.

1. Санхүүгийн тайланд бүртгэлтэй 6.7 сая төгрөгийн авлага нь 6-аас дээш жилийн хугацаатай барагдаагүй авлага байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.8-д “өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх” гэсэнтэй тус тус нийцэхгүй, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх

## 2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар өглөг, авлагын барагдуулалт болон зорилтот түвшний талаар авч үзнэ.

## 2.12. Шилэн дансны мэдээлэл

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 147 удаагийн мэдээллийг хуулийн хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

## 2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 12.0 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгснөөс хэрэгжүүлж зөвлөмжийн хэрэгжилт 90.0 хувьтай байна.

## 2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.



Залруулагдаагүй 43.2 сая төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тооцсон 11.2 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

“Хязгаарлалттай” дүгнэлт

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, СТОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дугаар заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### 3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 1. Байгууллагын хууль, эрх зүйн орчинтой асуудал

##### 1.1. Илрүүлэлт:

Тайлант онд үйл ажиллагааны зорилтот түвшин батлуулаагүй ажилласан.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.8-д “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн жилийн тайлан нь түүний зорилтын саналтай харьцуулан дүгнэж болох ижил үзүүлэлттэй байх бөгөөд шаардлагатай мэдээллийг агуулсан байна.” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### 1.2. Эрсдэл:

Хууль, тогтоомж, заавар, журмыг хэрэгжүүлээгүй байх, байгууллагын эдийн засгийн үр ашиг буурах;

##### 1.3. Өгсөн зөвлөмж:

Тухайн жилийн үйл ажиллагааны зорилтот түвшинг батлуулж, мөрдөж ажиллах;

##### 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана. 2020 онд зорилтот түвшний төлөвлөгөөгөө батлуулсан.

#### 2. Балансын данстай холбоотой асуудал

##### 2.1. Илрүүлэлт:

Тайлант оны эцэст харилцах данс нь 66.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байхад нэмэгдсэн өртгийн албан татварын өглөгийг өмнөх оноос 36.5 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8.-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлангийн "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Эрсдэл:

Хууль, тогтоомж, заавар, журмыг хэрэгжүүлээгүй, авлага, өр төлбөрийн тооцоог нийлж актаар баталгаажуулаагүй, барагдуулж ажиллаагүй байх;

2.3. Өгсөн зөвлөмж:

Татварын хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах, өр авлага үүсгэхгүй байх

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

**4. Аудит хийсэн санхүүгийн тайлан****4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	29,820,983.31	66,470,905.00
1.1.2	Дансны авлага	80,368,566.32	189,982,106.83
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага		
1.1.4	Бусад авлага		
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	65,015,652.51	70,229,431.80
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	454,847.00	9,570,992.70
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.10			
	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>175,660,049.14</b>	<b>336,253,436.33</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	3,139,051,183.25	2,969,514,691.73
1.2.2	Биет бус хөрөнгө	673,280,000.00	673,280,000.00
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>3,812,331,183.25</b>	<b>3,642,794,691.73</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,987,991,232.39</b>	<b>3,979,048,128.06</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	102,995,626.58	97,437,426.58
2.1.1.2	Цалингийн өглөг	247,099.86	
2.1.1.3	Татварын өр	169,568,216.25	196,270,509.83
2.1.1.4	НДШ–ийн өглөг		
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	20,362,759.33	6,233,550.00
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр		
2.1.1.12			
	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>293,173,702.02</b>	<b>299,941,486.41</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл	5,439,453.15	4,901,102.15
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5			
	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>5,439,453.15</b>	<b>4,901,102.15</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>298,613,155.17</b>	<b>304,842,588.56</b>

<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч:-төрийн	1,021,630,200.00	1,021,630,200.00
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,213,222,704.68	3,213,222,704.68
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	789,494,381.42	789,494,381.42
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-1,334,969,208.88	-1,334,969,208.88
2.3.10	Тайлант үеийн ашиг		-15,172,537.72
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>3,689,378,077.22</b>	<b>3,674,205,539.50</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,987,991,232.39</b>	<b>3,979,048,128.06</b>

**4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>636,357,204.43</b>	<b>803,723,484.55</b>
2	Борлуулалтын өртөг	-	-
3	<b>Нийт ашиг( алдагдал)</b>	<b>636,357,204.43</b>	<b>803,723,484.55</b>
4	Түрээсийн орлого		
5	Хүүгийн орлого	82,263.20	814,600.27
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	181,561,615.38	298,202,990.40
9	Борлуулалт, маркетингийн зардал	31,646,734.38	49,336,826.60
10	Ерөнхий ба удирдлагын зардал	797,371,289.31	1,068,626,941.74
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал		55,663.64
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	239,578.78	187,279.07
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг ( алдагдал)		
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>-10,777,361.90</b>	<b>(15,091,077.69)</b>
19	Орлогын татварын зардал	8,226.32	81,460.03
20	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>-10,785,588.22</b>	<b>(15,172,537.72)</b>
21	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>		
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>-10,785,588.22</b>	<b>(15,172,537.72)</b>
23	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	<b>Орлогын нийт дүн</b>		
25	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>		

**4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<u>869,893,879.80</u>	<u>1,046,220,970.01</u>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого түрээсийн орлого	713,055,784.67	808,451,405.82
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	8,882,457.00	6,158,988.00
1.1.4	Буцаан авсан албан татвар		
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		
1.1.6	Бусад мөнгөн орлого	147,955,638.13	231,610,576.19
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<u>839,051,959.40</u>	<u>996,695,724.89</u>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	260,779,426.00	298,289,101.86
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	79,117,079.76	95,961,987.64
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	11,270,455.00	14,188,755.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	132,283,192.96	144,169,221.98
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	4,756,352.00	6,581,100.00
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн		
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	161,897,018.20	134,233,580.61
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	111,100.00	6,158,988.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	188,837,335.48	297,112,989.80
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>30,841,920.40</b>	<b>49,525,245.12</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<u>2,038,724.98</u>	<u>5,477,614.27</u>
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	1,956,461.78	4,663,014.00
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	82,263.20	814,600.27
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		
2.1.8			
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<u>11,014,235.00</u>	<u>31,806,142.70</u>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	8,976,235.00	11,885,150.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	2,038,000.00	19,920,992.70
2.2.6			
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-8,975,510.02</b>	<b>-26,328,528.43</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<u>6,744,754.00</u>	<u>15,086,350.00</u>

3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	6,744,754.00	15,086,350.00
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.3	Төрөл бүрийн хандив		
3.1.4			
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>15,144,279.00</b>	<b>1,624,250.00</b>
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	15,144,279.00	1,624,250.00
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
3.2.4	Төлсөн ногдол ашиг		
3.2.5			
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-8,399,525.00</b>	<b>13,462,100.00</b>
4	Валютын ханшийн зөрүү		(8,895.00)
<b>5</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>13,466,885.38</b>	<b>36,649,921.69</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>16,354,097.93</b>	<b>29,820,983.31</b>
<b>7</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>29,820,983.31</b>	<b>66,470,905.00</b>



**4.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн Өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	<b>2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>1,021,630,200.00</b>	<b>1,583,463,801.59</b>	<b>116,214,381.42</b>	<b>-1,324,183,620.66</b>	<b>1,397,124,762.35</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
3	Залруулсан үлдэгдэл					
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)				-10,785,588.22	-10,785,588.22
5	Бусад дэлгэрэнгүй орлого					
6	Өмчид гарсан өөрчлөлт			673,280,000.00		673,280,000
7	Зарласан ногдол ашиг					
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		1,629,758,903.09			1,629,758,903.09
9	<b>2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>1,021,630,200.00</b>	<b>3,213,222,704.68</b>	<b>789,494,381.42</b>	<b>-1,334,969,208.88</b>	<b>3,689,378,077.22</b>
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
11	Залруулсан үлдэгдэл					
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				-15,172,537.72	-15,172,537.72
13	Бусад дэлгэрэнгүй орлого					
14	Өмчид гарсан өөрчлөлт					
15	Зарласан ногдол ашиг					
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					
17	<b>2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>1,021,630,200.00</b>	<b>3,213,222,704.68</b>	<b>789,494,381.42</b>	<b>-1,350,141,746.60</b>	<b>3,674,205,539.50</b>

**5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Огноо: <b>2020.03.11</b>	Аудитын нэр: <b>2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код: <b>САГ-2020/22/СТА-ТӨҮГ</b>
Шалгагдсан байгууллагын нэр: <b>Мэдээлэл, технологийн үндэсний парк ТӨҮГ</b>	Сая төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Санхүүгийн тайланд бүртгэлтэй 6.7 сая төгрөгийн авлага нь 6-аас дээш жилийн хугацаатай барагдаагүй авлага байна.	6.7	Албан шаардлага	Захирал, ерөнхий нягтлан бодогч	Э.Цогтгэрэл Д.Цэрэндолгор
2	Тайлант онд үйл ажиллагааны зорилтот түвшин батлуулаагүй ажилласан.	-	Зөвлөмж	Захирал, ерөнхий нягтлан бодогч	Э.Цогтгэрэл Д.Цэрэндолгор
3	Тайлант оны эцэст харилцах данс нь 66.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байхад нэмэгдсэн өртгийн албан татварын өглөгийг өмнөх оноос 36.5 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн	36.5	Зөвлөмж	Захирал, ерөнхий нягтлан бодогч	Э.Цогтгэрэл Д.Цэрэндолгор
	Дүн	43.2			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 18

№ 02/121

Улаанбаатар хот

СДҮГ-2020/22/СТА-ТӨЧГ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-т заасан цаглабарт хугацааны дагуу Мэдээлэл, технологийн үндэсний парк ТӨҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Санхүүгийн тайланд бүртгэлтэй 6.7 сая төгрөгийн авлага нь 6-аас дээш жилийн хугацаатай барагдаагүй авлага байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.8-д “өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх” гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх...” Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1 -д “...дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага албан шаардлага өгнө” гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Зөрчлийг таслан зогсоож, авлага барагдуулах тодорхой үйл ажиллагаа явуулах, давтан гаргахгүй байхад анхаарах;
2. Биелэлтийг 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Мэдээлэл, технологийн үндэсний парк ТӨҮГ-ын захирал Э.Цогтгэрэл, ерөнхий нягтлан бодогч Д.Цэрэндолгор нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
АУДИТОР Б.ЭНХЖИН  
“БАЯН ТАШААГИЙН ЭХ АУДИТ” ХХК-ИЙН  
АУДИТОР Т.ХОРОЛСҮРЭН

ЗӨВШӨӨРСӨН:

МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ҮНДЭСНИЙ  
ПАРК ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ

Э.ЦОГТГЭРЭЛ  
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ  
Д.ЦЭРЭНДОЛГОР

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

